



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/245

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас бүртгэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.10, 8.11, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 59 дүгээр тушаал, 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн мэдэгдлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хямдруулалттай, 26 долоо хоногийн хугацаатай, 50,000 (тавин мянга) ширхэг, нийт 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1359 кодтой, ЗГХБ-Б-26-537 нэртэй Засгийн газрын үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэсүгэй.

2. "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид үнэт цаас хадгалуулах мэдэгдэл хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалаар бүртгэгдсэн Засгийн газрын үнэт цаасыг олон нийтэд арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.

4. Засгийн газрын үнэт цаас бүртгэгдэн, арилжихтай холбоотой мэдээллийг нийтэд хүргэх ажлыг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, шимтгэлийг холбогдох журмын дагуу тооцон авахыг Захиргаа, санхүүгийн газар (Х.Эрдэнэбүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1526330605

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-д
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №1359**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2026/06/22

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас хадгалуулах тухай
Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн №1/2026 тоот тушаал
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Засгийн газрын үнэт цаас
Үнэт цаасны төрөл: /хямдруулалттай, купонтой/	Хямдруулалттай
Арилжааны хэлбэр: /ялгавартай үнэтэй, нэгдсэн үнэтэй/	Ялгавартай үнэтэй
Үнэт цаасны нэр:	ЗГХБ-Б-26-537
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус
Үнэт цаасны тоо: /ширхэг/	50,000 /тавин мянга/
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100,000 /нэг зуун мянга/
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	5,000,000,000 /таван тэрбум/
Үнэт цаасны хугацаа: /долоо хоног, сар/	26 долоо хоног
Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа: /давтамж/	Хугацааны эцэст
Өрсөлдөөнт бус нийт саналд хуваарилах дээд хэмжээ: /%/	1,500,000,000 /нэг тэрбум таван зуун сая/
Нэг оролцогчид хуваарилах саналын хязгаар: /төгрөг/	25%
Үнэт цаас арилжих өдөр	2026.06.24
Үнэт цаасны хугацаа дуусах огноо	2026.12.23

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Т.ХАШ-ЭРДЭНЭ